

## ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ

ГЕГ-ын дэргэдэх Хяналтын нэгдсэн төв нь Гаалийн лавлах 1800-1281 болон Засгийн газрын 11-11 лавлах төвөөр дамжуулан гаалийн харилцаанд оролцогчдод гаалийн байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөө, мэдээ мэдээлэл өгөхөөс гадна гаалийн байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын ёс зүйтэй болон гаалийн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авч холбогдох газар хэлтэс, газар хороодод шилжүүлэн, шуурхай шийдвэрлүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.

2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Гаалийн байгууллага иргэд, аж ахуйн нэгжээс нийт 132 гомдол мэдээлэл хүлээн авсан байна.

Үүнд:

- Гаалийн байгууллагатай холбоотой санал, хүсэлт – 18
- Талархал – 1
- Гомдол - 113 бүртгэгдсэн байна.

	Гомдол	Санал	Хүсэлт	Талархал	Нийт
<b>Засгийн газрын 11-11 Төв</b>	85	7	11	1	<b>104</b>
<b>Гаалийн лавлах 1800-1281</b>	28	-	-	-	<b>28</b>

Хүлээн авсан нийт гомдлыг холбогдох чиглэлээр нь задалж үзвэл:

- Гаалийн хяналт, бүрдүүлэлттэй холбоотой - 63 /55.75%/
- Албан хаагчийн ёс зүйтэй хамааралтай – 16 /14.16%/
- Гаалийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоогүй - 14 /12.40%/
- Гаалийн хорио цээртэй холбоотой - 9 /7.96%/
- Программ, сүлжээний саатал болон техник хэрэгслийн гэмтэл догогдлоос шалтгаалан цаг хугацаа алдсан талаар - 8 /7.08%/
- Барааны ангилал, үнэлгээтэй холбоотой - 3 /2.65%/ гомдол тус тус бүртгэгдсэнийг холбогдох нэгжид шилжүүлэн, хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлүүлж ажилласан байна.

Тус хугацаанд Гаалийн зөрчилтэй хамааралтай гомдол мэдээлэл бүртгэгдээгүй болно.

Нийт гомдлыг газар хороодоор нь хувьчилж авч үзвэл:

- Нийт гомдлын дийлэнх хувийг ЗҮГГ – 45.13%
- ГЕГ-19.47%
- УБГГ-10.62%
- Үлдсэн 24.78%-ийг бусад гаалийн газар хороодтой холбоотой гомдол мэдээлэл эзэлж байна (СЭГГ-7.96%, УХШИГГ-6.19%, ЧХОУНБГГ-3.55%, БӨГГ-2.66%, СШГГ-1.77%, ХОГГ-1.77%, ГСГГ-0.88%)

№	ГЕГ ба газар, хороо	Санал хүсэлт, гомдлын тоо/ хувь хэмжээ	
1	Гаалийн Ерөнхий Газар	22	19.47%
2	Улаанбаатар дахь ГГ	12	10.62%
3	Замын-Үүд дэх ГГ	51	45.13%
4	Сэлэнгэ аймаг дахь ГГ	9	7.96%
5	Улс хоорондын шуудан илгээмж дэх ГГ	7	6.19%
6	Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь ГГ	4	3.55%
7	Гашуунсухайт дахь ГГ	1	0.88%
8	Ховд аймгийн Булган дахь ГГ	2	1.77%
9	Сайншанд дахь ГГ	2	1.77%
10	Баян-Өлгий аймаг дахь ГГ	3	2.66%
	Нийт	<b>113</b>	<b>100%</b>

Тайлант хугацаанд Гаалийн лавлах 1800-1281, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандсан гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шийдвэрлэгдээгүй, хариу өгөөгүй гомдол, санал, хүсэлт байхгүй болно.

Гаалийн байгууллагын Албан хаагчийн ёс зүйтэй хамааралтай 16 гомдлын шийдвэрлэлтийг авч үзвэл:

13 гомдол нь нотолгоо баримтгүй, үндэслэлгүй байна.

1 гомдлын дагуу холбогдох албан хаагчид сахилгын арга хэмжээ авч, 2 албан хаагчид ГЕГ-ын даргын А/534 тушаалаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 2.2.1, 2.2.2, 2.2.3, 2.2.8 дахь заалтуудыг чанд баримтлан, гаалийн харилцаанд оролцогч нартай зөв боловсон, ёс зүйтэй харьцаж ажиллахыг анхааруулсан байна.

## ХЯНАЛТЫН НЭГДСЭН ТӨВ